



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/214/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МУЗЕЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273465 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.20 № 01/69
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Музей нь тайлант оноос эхлэн улсын төсвөөс болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч тайлагнадаг Соёлын яамны харьяа байгууллага болсон байна. Тайлант онд "Төв түмний цэнгэл", "Нүүдэлчин монгол-2022", "Үл хөдлөх дурсгалын улсын тооллого"-ийг зохион байгуулж, амжилттай оролцож хэд хэдэн онцлог ажлууд хийгдсэн байна. "Үл хөдлөх дурсгалын улсын тооллого"-ыг Төв аймгийн 27 суманд зохион байгуулж, 5 маршрутаар, 12 мянган км газар явж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,911,098.50	40,276,882.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	6,027,779.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	6,027,779.51
3121	Төгрөг	00.00	6,027,779.51
31211	Төрийн сангийн харилцах	00.00	6,027,779.51
35	БАРАА МАТЕРИАЛ	25,911,098.50	34,249,102.50
354	Хангамжийн материал	25,911,098.50	34,249,102.50
35410	Бичиг хэргийн материал	1,438,150.00	1,576,080.00
35420	Аж ахуйн материал	15,399,490.00	19,566,500.00
35440	Түлш, шатах тослох материал	153,000.00	5,324.00
35470	Бусад хангамжийн материал	8,920,458.50	13,101,198.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,102,466,315.55	1,048,485,129.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,102,466,315.55	1,048,485,129.46
392	Биет хөрөнгө	1,052,324,315.55	996,711,129.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	626,932,823.00	626,932,823.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-502,440,847.00	-545,379,561.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,000,000.00	27,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,000,000.00	-18,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,695,384.15	39,195,784.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,426,573.74	-27,275,392.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,476,540.00	39,476,540.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,340,690.90	-26,598,043.31
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	876,437,880.00	877,112,880.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,229,750.00	5,229,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-239,949.96	-983,649.96
393	Биет бус хөрөнгө	50,142,000.00	51,774,000.00
39301	Програм хангамж	290,000.00	1,970,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-98,000.00	-146,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,950,000.00	49,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,128,377,414.05	1,088,762,011.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,128,377,414.05	1,088,762,011.47
51	Засгийн газрын хувь оролцоо	1,128,377,414.05	1,088,762,011.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	402,382,470.00	402,382,470.00
51101	Өмч: - төрийн	402,382,470.00	402,382,470.00
512	Хуримтлагдсан үр дүн	-147,583,206.79	-187,198,609.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-147,583,206.79	-147,583,206.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-39,615,402.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,578,150.84	873,578,150.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,128,377,414.05	1,088,762,011.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	356,137,431.00	321,301,442.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,928,331.00	18,748,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	101,928,331.00	18,748,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,868,331.00	18,658,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,426,000.00	16,078,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	98,442,331.00	2,580,600.00
120009	Бусад орлого	60,000.00	90,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	254,209,100.00	302,552,842.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	230,987,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	230,987,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	11,343,042.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	11,343,042.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,209,100.00	60,222,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,209,100.00	60,222,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	324,982,522.74	360,916,844.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,982,522.74	360,916,844.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315,983,582.80	352,656,742.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,413,940.52	201,514,009.06
210101	Үндсэн цалин	118,190,446.83	148,056,687.22
210102	Нэмэгдэл	43,084,493.69	36,440,627.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,139,000.00	12,960,500.00
210104	Урамшуулал	00.00	4,056,194.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,990,087.54	25,227,869.53
210201	Тэтгэврийн даатгал	15,998,231.28	17,663,347.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,757,414.14	1,924,080.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,395,851.20	1,539,264.39
210204	Ажилгүйдлийн даатгал	348,962.73	372,834.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,489,628.19	3,728,343.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,659,882.00	41,931,912.00
210301	Гэрэл, цахилгаан	3,275,732.00	4,415,807.00
210302	Түлш, халаалт	35,112,055.00	37,129,510.00
210303	Цэвэр, бохир ус	1,272,095.00	386,595.00

2104	Хангамж, бараа материалын зардал	2,896,290.00	3,675,376.00
210401	Бичиг хэрэг	405,500.00	1,492,500.00
210402	Тээвэр, шатахуун	624,940.00	1,340,176.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	599,220.00	666,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,266,630.00	176,650.00
2105	Нормативт зардал	472,450.00	487,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	472,450.00	487,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,963,780.00	7,805,890.00
210604	Урсгал засвар	2,963,780.00	7,805,890.00
2107	Томилолт, зочны зардал	416,000.00	812,000.00
210702	Дотоод албан томилолт	416,000.00	812,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,157,090.00	7,073,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,414,540.00	7,073,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,700.00	00.00
210807	Газрын төлбөр	149,850.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,014,062.74	64,128,586.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,292,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,014,062.74	62,836,586.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,998,939.94	8,260,101.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,824,000.00	1,560,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,424,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	1,560,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,174,939.94	6,700,101.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,174,939.94	6,700,101.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	31,154,908.26	-39,615,402.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,242,784.76	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,192,784.76	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	50,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=-(145-225)	-3,242,784.76	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	27,912,123.50	-39,615,402.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>257,695,100.00</u>	<u>318,720,842.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,486,000.00	16,168,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,486,000.00	16,168,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,426,000.00	16,078,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,426,000.00	16,078,000.00
120009	Бусад орлого	60,000.00	90,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	254,209,100.00	302,552,842.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	230,987,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	230,987,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	11,343,042.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	11,343,042.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,209,100.00	60,222,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,209,100.00	60,222,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>257,020,100.00</u>	<u>303,837,662.49</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	257,020,100.00	303,837,662.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	248,021,160.06	295,577,560.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,413,940.52	201,514,009.06
210101	Үндсэн цалин	118,190,446.83	148,056,687.22
210102	Нэмэгдэл	43,084,493.69	36,440,627.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,139,000.00	12,960,500.00
210104	Урамшуулал	00.00	4,056,194.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,990,087.54	25,227,869.53
210201	Тэтгэврийн даатгал	15,998,231.28	17,663,347.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,757,414.14	1,924,080.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,395,851.20	1,539,264.39
210204	Ажилгүйдлийн даатгал	348,962.73	372,834.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,489,628.19	3,728,343.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,659,882.00	41,931,912.00
210301	Гэрэл, цахилгаан	3,275,732.00	4,415,807.00
210302	Түлш, халаалт	35,112,055.00	37,129,510.00
210303	Цэвэр, бохир ус	1,272,095.00	386,595.00

2104	Хангамж, бараа материалын зардал	2,180,320.00	1,641,050.00
210401	Бичиг хэрэг	542,600.00	478,500.00
210402	Тээвэр, шатахуун	558,500.00	496,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	599,220.00	666,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	00.00
2105	Нормативт зардал	1,376,500.00	620,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,376,500.00	620,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,267,280.00	9,944,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	297,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,025,450.00
210604	Урсгал засвар	1,970,280.00	8,918,700.00
2107	Томилолт, зочны зардал	416,000.00	812,000.00
210702	Дотоод албан томилолт	416,000.00	812,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,717,150.00	11,449,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,974,600.00	11,449,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,700.00	00.00
210807	Газрын төлбөр	149,850.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,436,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,436,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,998,939.94	8,260,101.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,824,000.00	1,560,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,424,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	1,560,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,174,939.94	6,700,101.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,174,939.94	6,700,101.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	675,000.00	14,883,179.51
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	675,000.00	8,855,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	675,000.00	8,855,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	675,000.00	8,855,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	675,000.00	8,855,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-675,000.00	-8,855,400.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	6,027,779.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	6,027,779.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,432,470.00	845,181,603.80	-139,701,938.39	1,057,912,135.41
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,432,470.00	845,181,603.80	-139,701,938.39	1,057,912,135.41
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,771,972.07	-20,771,972.07
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-147,583,206.79	1,128,377,414.05
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-147,583,206.79	1,128,377,414.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-147,583,206.79	1,128,377,414.05
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-39,615,402.58	-39,615,402.58
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-187,198,609.37	1,088,762,011.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	253,203,500.00	241,127,720.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	253,203,500.00	241,127,720.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	251,635,500.00	239,567,720.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,529,700.00	182,610,339.64
210101	Үндсэн цалин	93,957,700.00	131,909,404.39
210102	Нэмэгдэл	29,836,500.00	34,587,240.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,608,000.00	12,057,500.00
210104	Урамшуулал	46,127,500.00	4,056,194.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,941,200.00	22,864,910.85
210201	Тэтгэврийн даатгал	15,600,000.00	15,669,763.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,835,300.00	1,831,736.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,468,200.00	1,465,389.48
210204	Ажилгүйдлийн даатгал	367,100.00	354,365.58
210205	Эрүүл мэндийн даатгал	3,670,600.00	3,543,655.70
2104	Хангамж, бараа материалын зардал	2,455,900.00	1,641,050.00
210401	Бичиг хэрэг	622,400.00	478,500.00
210402	Тээвэр, шатахуун	496,500.00	496,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	557,000.00	666,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	780,000.00	0
2105	Нормативт зардал	823,000.00	620,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	823,000.00	620,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,603,000.00	9,777,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,400,500.00	799,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,250,000.00	1,025,450.00
210604	Урсгал засвар	12,952,500.00	7,952,500.00
2107	Томилолт, зочны зардал	812,800.00	812,000.00
210702	Дотоод албан томилолт	812,800.00	812,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,149,900.00	12,304,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,149,900.00	12,304,670.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,320,000.00	8,936,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,320,000.00	8,936,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,568,000.00	1,560,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,568,000.00	1,560,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,568,000.00	1,560,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	253,203,500.00	247,155,500.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	230,987,500.00	230,987,500.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	230,987,500.00	230,987,500.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	22,216,000.00	16,168,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,216,000.00	16,168,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	6,027,779.51
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	37	37
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7
620003	Үйлчлэх ажилтан	10	10
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18	18
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	18	18

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		10,877,968.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ		10,877,968.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,877,968.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,669,305.43
210101	Үндсэн цалин		9,669,305.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,208,663.19
210201	Тэтгэврийн даатгал		1,208,663.19
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	11,343,042.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		11,343,042.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		11,343,042.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Музей нь соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, бүртгэн баримтжуулж, хадгалж хамгаалах чиг үүрэг бүхий Соёлын яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Музей нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 47 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 92%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Музейн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар “Орон тоо, цалингийн санг батлах тухай” шинэчлэн баталж, төв Музей, Манзуширын хийд гэсэн бүтэц, зохион байгуулалттай, тайлант онд Музейн дарга 1, гүйцэтгэх 9, үйлчилгээний ажилтан 8, бүгд 18 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Музей нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Музейн тухай хууль
- Соёлын тухай хууль

Төв аймгийн Музейн даргын 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл байгуулах тухай" А/12 тушаал, 3 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Музейн дотоод хяналт шалгалтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 9 арга хэмжээг хагас, бүтэн жилээр төлөвлөн санхүү төсөв, эд хөрөнгийн ашиглалтын талаар болон шилэн дансны хэрэгжилтийн чиглэлээр хийж хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын дотоод хяналтын зөвлөл нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Музей нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын А/465 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Музей нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,615.4 мянган төгрөгөөр буюу 3,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	6,027.8	6,027.8
Авлага	0	0	0
Бараа материал	25,911.1	34,249.1	8,338.0
Үндсэн хөрөнгө	1,102,466.3	1,048,485.1	-53,981.2
Нийт хөрөнгө	1,128,377.4	1,088,762.0	-39,615.4
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,128,377.4	1,088,762.0	-39,615.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,128,377.4	1,088,762.0	-39,615.4

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн дансанд орлого зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 53,981.2 мянган төгрөгөөр буурсан байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,088,762.0 мянган төгрөг болж 39,615.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 296,889.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Музейгээс дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 5,679.2 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг орон нутгаас 60,222.3 мянган төгрөг, улсын төсвөөс 230,987.5 мянган төгрөг, нийт 291,209.8 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Тайлант хугацаанд батлагдсан төсөвт тодотгол, өөрчлөлт ороогүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /соёл, урлаг/ хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 230,987.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 60,222.3 мянган төгрөг, нийт 291,209.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 6,700.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 224,992.3 мянган төгрөг буюу 98,4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 6,700.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702 соёл урлаг 80101үндсэн үйл ажиллагааны зардал	220,219.5	214,337.5	5,882.0	97,3
2	71702 соёл урлаг 80215 эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,000.0	9,894.8	105.2	98,9
3	71702 соёл урлаг 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	768.0	760.0	8.0	99,0
4	71702 соёл урлаг 80111 төрийн өмчийн барилгын тогтмол зардал	46,451.1	43,598.6	2,852.5	94,8
5	71702 соёл урлаг 80112 нийтлэг үйлчилгээ	13,771.2	10,388.7	3,382.5	75,4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Музейн нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 11,343.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Музей тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бараа үйлчилгээний бусад зардалд 10,878.0 мянган төгрөг зарцуулж, 465.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71702	2022.01.01-2022.12.31	Соёл урлаг	Хөтөлбөр 98,7 %	291,209.8	278,979.6

Төв аймгийн Музей нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 12,230.2 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Музейн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Соёлын сайдын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Музейн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан 2022 оны нийт зарлага 213,359.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,200.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,400.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Музей нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Музейн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Музейн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад алдаа, зөрчил илрээгүй тул асуудлын бүртгэл хөтлөөгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 41 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	836.9	2	836.9	100
Нийт дүн	2	836.9	2	836.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Музей дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 62,858.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 62,858.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1.Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зардлыг 62,858.3 мянган төгрөгөөр илүү татагдаж, тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 3,176.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 90.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,086.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага тогтоож хүргүүлээ.

5.2 Төлбөрийн акт

1. Тус байгууллага тайлант онд салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг хийж 90.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд 3,086.9 мянган төгрөгөөр 250 ширхэг комик ном хэвлүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-д “хэвлэлийн захиалгын төлбөр” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зардлыг 62,858.3 мянган төгрөгөөр илүү татагдаж, тайлагнасан байна.	1	62,858.3					1	62,858.3				
Дүн	1	62,858.3					1	62,858.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг хийж 90.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	90.0	1	90.0								
Төсвийн хөрөнгөөр 3,086.9 мянган төгрөгөөр 250 ширхэг комик ном хэвлүүлж зарцуулсан байна.	1	3,086.9			1	3,086.9						
Дүн	2	3,176.9	1	90.0	1	3,086.9						